

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№23/581

ШУС, НУС

2022

**“ӨЧҮҮХЭН ТЭМДЭГЛЭЛ”-ИЙН ӨЧНӨӨН ОЛОН МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙ  
ТҮҮХЭН ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛ**

(1921 оны ардын хувьсгалын товч толин тусгал. Ардын хувьсгалын 100 жилийн ойд)

Т.Баасансүрэн\*

\*Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, доктор (Ph.D), профессор

**Түлхүүр үгс:** С.Буяннэмэх, сэтгүүлчийн үйл ажиллагаа, тэмдэглэл, ардын хувьсгал.

Орчин үеийн Монголын уран зохиол, сэтгүүл зүйн анхдагч нэрт зүтгэлтэн Сономбалжирын Буяннэмэхийн бүтээл туурвилаас хамгийн бага судлагдсан нь түүний сэтгүүл зүйн үйл ажиллагаа, уран нийтлэл болно. Доктор Г.Дэлэг анхалж өнгөрсөн зууны жараад онд С.Буяннэмэхийн нийтлэлд анхаарал хандуулж, сүүлд доктор, профессор Л.Норовсүрэн түүнийг нь өргөжүүлж гүнзгийрүүлсэн байдаг. Өчүүхэн судлаач миний бие өөрийгөө үл голж “Сономбалжирын Буяннэмэхийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ” нэг сэдэвт зохиол бичиж 2019 онд нийтийн хүртээл болгохдоо “С.Буяннэмэхийн сэтгүүлчийн үйл ажиллагаа” хэмээх нэг бүлгийг түүний нийтлэл зүйд бүхэлд нь зориулсан билээ. 1997 онд Г.Дүйнхэржавын бичиж хэвлүүлсэн “Сономбалжирын Буяннэмэхийн улстөрийн намтар” номд зохиогчийн нийтлэлийн чиглэлээр туурвисан бүтээлүүдийн жагсаалт буй. 2013 онд уншигчдын хүртээл болгосон М.Зулькафиль, Б.Уянга нарын “Сэтгүүл зүйн шүүмж судлал: түүний

өчигдөр ба өнөөдөр” номд Монголын сэтгүүл зүйн шүүмж судлалыг үндэслэгч гэдэг талаас нь товч хөндөөд орхисон байгаа. С.Энхбаяр судлаач Сономбалжирын Буяннэмэхийн уран бүтээлээр докторын зэрэг хамгаалж, цөөн тооны хүн магистрын болоод бакалаврын дипломын сэдэв бичихдээ гол төлөв уран зохиолд нь голлож анхаарсан байдаг. Өөрөөр хэлбэл С.Буяннэмэхийн сэтгүүл зүйн бүтээлүүд өнөөг хүртэл анхаарлын гадна явж ирсэн, бүрэн гүйцэд судлагдаагүй сэдэв гэж хэлж болно.

“Монголын шилдэг нийтлэл” эрдэм шинжилгээ, судалгааны төв /ТББ/ үүнийг харгалзан үзэж Монголын хувьсгалт хэвлэлийг үндэслэгч Сономбалжирын Буяннэмэхийн нийтлэлүүд /1920 оны “Үнэн” сонины 6 дугаарыг тэр бээр Эрхүү хотноо гардаж гаргасан/-ийг тусгайлан боть болгон эмхэтгэж, холбогдох судалгааны хамт хэвлэлд бэлтгээд байгаа билээ. Энэ чиглэлээр өөр тоймтой томоохон судалгаа шинжилгээ, ялангуяа С.Буяннэмэхийн нийтлэлүүдэд задлан шинжлэл хийсэн зүйлс “Мартагдашгүй учрал”, “Ленин” зэрэг цөөн бүтээлийг эс тооцвол байхгүй болно.

Иймд Сономбалжирын Буяннэмэхийн “Өчүүхэн тэмдэглэл” нийтлэ-

лийн талаар өөрийн санал бодлыг уншигчидтайгаа хуваалцахаар шийдлээ. Энэ бол түүний бичсэн тавхан хуудас жижигхэн тэмдэглэл. Үйл явдал нь 1920 оных. Монгол, Оросын хилийн зурвас дахь Дээд Шивээ ба Хиагтад болж буй нэгэн өдрийн сонирхолтой содон үйл явдлыг зураглан дүрсэлж буулгажээ. Эхнээс эцсийн өгүүлбэрийг дуустал сонжин сонирхож нягтлан бүртгэж үзвэл Монгол Улсын түүхэнд болоод “Буяннэмэх судлал”-д туйлын чухал ач холбогдолтой олон мэдээллийг өөртөө агуулсан байв. 17-хон настай идэр залуу байхдаа өөрийн нүдээр үзсэн үйл явдлаа илүү дутуу үггүй, тоочин нуршихгүйгээр тов тодорхойгоор сэтгэлд хоногштол дүрслэн үзүүлжээ. 1920 оны Монгол орон дахь цаг төрийн үймээн, хил хязгаар нутгийн түгшүүрт байдал нүдэнд үзэгдэх адил болж байна.

“Өчигдөр нь их буугийн дуу ямагт хүдэн хүдэн гэж сонсогдож байсан бүлгээ. Дээд Шивээний баруун этгээдийн уул нь битүү нарс ургасан бөгөөд тэрхүү нарсны дотор мэр сэр модон байшингууд байна. Тэрхүү байшингийн нэгэнд хиагтын гамингаас дүрвэж ирсэн хятад хүмүүстэй би ч хамт сууж байв. Өглөөний шар наран цонхонд тусаад бүгдээр цай ууж хар талх идэлцэв. Дээд Шивээ бол буфер улсын нутаг тул лав гамин хүрч ирж чадахгүй гэж бид нар их л тайван сууцгаав. Гагцхүү өчигдрийн дуугарсан их буу нь чухам юу болсон бол гэхээс аягатай цайгаа түргэн ууцгааж байв. За байз хоёулаа явъя гэж лам цагдаа гэгч Дамба гүйн гарч хоёр морь эмээллэв. Удалгүй түймэр түймэр гэсээр орж ирэв. Бид нар цөм гарч үзвэл манай өмнөх уулын зүүн өмнөөс тэнгэр бүрхсэн хөх утаа гарч түүний дунд бөөн бөөн гал бадарч байх нь манайхаас тун ойрхон санагдав. Явъя, явъя очиж үзье

гэлцэн хоёулаа морины олмоо чангалав. Хүүхэд минь та нар гартаа юу ч үгүй атал дэмий явж гаминд баригдвал горьгүй шүү гэж Дамбын эх чавганц хэлж байна. За гайгүй морь сайн тул юунаас айх вэ гэж бид хоёр довтлон одов. Дөнгөж уулын хөтөл дээр гартал Хиагт хот маань харин гал утаа хоёроор бүрхээд түүний дунд байн байн буу тасхийж, олон хүмүүс бархиралдан тэрэг чарга түржигнэх нь үнэхээр нэг их хөл хөдөлгөөн болжээ. Гэнэт үзвэл тоо томшгүй олон морин тэрэгтэй орос буриад хүмүүс Хиагтаас эд бараа олзолж Дээд Шивээний гол замаар хойш урагш шоргоолж мэт бужигнаж байна. За энэ лав манай монгол цэргүүд гаминг үлдэн гаргаад Хиагт хотыг шатааж Дээд Шивээний дэргэдэх айлууд олз омог хайж яваа ийм хэрэг болжээ гэж дотроо төсөөлсөн бөгөөд бас энэ их хайран хотыг юунд шатаасан юм бол гэж элдвээр бодон явав. Гэтэл бас хааяа хааяа буун дуу гарна. Бас л гамингууд байсаар юм уу даа гэж гайхав. Гэтэл энэ их түймрийг тавьсан эзэд нь тэр олон бараа дээрэмдэгчид бөгөөд тэд нар онгойсон сав бүрд орж гэсэн шүдэнз бүр бялт болон асаад тийнхүү байшин бүрээс гал гарч унтрах аргагүй болж цагдаа цэргүүд энгийн шунагуудыг хөөх гэж хааяа хааяа буун дуу гаргаж байжээ” хэмээн “Өчүүхэн тэмдэглэл” эхэлж байна.

**Х**ятадын гамин цэрэг 1919 онд нийслэл Хүрээг эзлэн Монголын тусгаар тогтнолыг устгаж, удалгүй Барон Унгерн цагаан цэрэг Монголд цөмрөн орж гамингуудтай тулалдан Хиагт руу зугтаж гарсан тэр үеийн Монгол орон, зах хязгаар нутгийн үнэн бодит байдал ямархуу дүр төрхтэй байсныг марзан Шаравын “Монголын нэг өдөр” дэлгэмэл монгол зураг лугаа адил тод томруун зураглан буулгажээ.

Их буу хүдэн хүдэн дуугарч, энд тэндгүй буун дуу тасхийж, их гал түймэр дүрэлзэн асаж, хөх утаа агаар тэнгэрийг бүрхэж байна. Олон хүмүүс бархиралдан, тэрэг чарга түржигнэж, тоо томшгүй олон морин тэрэгтэй орос буриад хүмүүс Хиагтаас эд бараа олзлон дээрэмдэж Дээд Шивээний гол замаар хойш урагш шоргоолж мэт бужигнаж байлаа гэжээ. Их түймрийг тавьсан хэргийн эзэд нь эд бараа дээрэмдэгчид ажээ. Энэ бүгдийг залуу хөвгүүн С.Буяннэмэх лам цагдаа Дамбын хамт нүдээр харж, чихээр сонсон явж байна. Гээсэн шүдэнз бүр бялт болон асаад тийнхүү байшин бүрээс гал гарч унтрах аргагүй болж цагдаа цэргүүд шуналт дээрэмчдийг хөөх гэж хааяа буу тавьж байсан нь тэр юмсанж. Хиагт, тэндхийн тэмцэл хөдөлгөөн, тонуул дээрмийн үнэн бодит ерөнхий өнгө төрх толинд буух адил тодрон харагдаж байна. Уг үйл явдлыг ингэж нийтлэлийн хэлээр цааснаа буулгаж үлдээсэн нь С.Буяннэмэхийн “Өчүүхэн тэмдэглэл”-ийн онцгой үнэ цэнтэй мэдээлэл. Цааш ахиулан уншвал “Тэр үед бид хоёр хэзээний хотын дунд галын дэргэд хүрсэн байв. Нэгэн хүн өндөр дуугаар хашхиран сэлэм гялалзуулж, бараа авсан хүнийг шууд буудаж ална гэж зандарч байв. Тэр нь галт хотыг сэргийлэгч жанжин дүйнхарын да лам хэмээх Хасбаатар ажээ. Түүнтэй би хэзээний танил бөлгөө. Чи үзэгдэхгүй хаа байсан, яахан гарч ирэв гэж надаас хараалтай ерөөлтэй хавсарган асууж байна. Ай лам та надад буу зэвсэг юу ч үгүй тул надад нэг буу өгнө үү гэв. Чи Алтанбулаг дээр очиж жанжинд хэлээд авах хэрэгтэй гээд бас цааш хашхиран бархирсаар одов. Ер нь их л галзуу хөөрүү хүн бөлгөө” гэжээ.

Онцгой сонин мэдээлэл. 1921 оны ардын хувьсгалт үйл хэргийн нэг

бодит бие хүн, түүхэнд нэр нь үе үе дурдагддаг Хасбаатарын тухай өгүүлжээ. Галт хотыг сэргийлэгч жанжин дүйнхарын да лам гэж тодотгосон байна. Тухайн цаг үед Хасбаатар галт хотыг буюу Хиагтыг сэргийлэгч алба хашиж байж. Эндээс С.Буяннэмэх нь 1921 оны ардын хувьсгалт үйл хэрэгт оролцогчидтой, тухайлбал Хасбаатартай эртний танил байсан нь ойлгогдож байна. “Чи үзэгдэхгүй хаа байсан, яахан гарч ирэв гэж надаас хараалтай ерөөлтэй хавсарган асууж байна” гэжээ. Хэрэгцээтэй чухал цаг үед үзэгдэхгүй алга боллоо гэж уурсах, хүрэлцэн ирснийг нь үзээд баясахыг хослуулж байж Хасбаатар түүнээс ингэж асуусан байна. С.Буяннэмэх бусдад үгүйлэгдсэн хувьсгалт үйл хэрэгт хэрэгтэй хүн байсан аж.

**З**алуу хүү С.Буяннэмэх надад буу зэвсэг өгөөч гэж түүнээс гуйж байна. Хасбаатар хариуд нь “Алтанбулагт очиж жанжинд хэлээд авах хэрэгтэй гээд цааш хашхиран бархирсаар одов” гэжээ. Араас нь залгуулаад тэр бээр “Ер нь их л галзуу хөөрүү хүн бөлгөө” гэсэн 6 үгтэй ганц өгүүлбэр шигтгэж өгсөн аж. Буу зэвсэг зэргийг бүх цэргийн жанжин Сүхбаатар өөрөө мэдэж байжээ гэдэг нь эндээс ойлгогдоно. Өөр нэмж хэлэх нэг сонин мэдээлэл бол жанжин дүйнхэрийн да лам Хасбаатарт “Өчүүхэн тэмдэглэл”-ийг зохиогчоос өгсөн товч тодорхойлолт юм. “Галзуу хөөрүү” гэсэн байна. Хасбаатар ламтан нь сүүлд “Толбо нуурын тулалдаан”-д оролцож явсан нэгэн бөгөөд нэг хэсэг нь түүнийг баатар зоригтон гэж бичсэн байхад нөгөө нэг нь хулчгар аймхай, сагсуу хөөрүү гэж тодорхойлсон нь ч бас бий. Нийтлэлч С.Буяннэмэх болохоор “Ер нь их л галзуу хөөрүү хүн бөлгөө” хэмээжээ. Үүнд үнэний хувь байгаа гэж би

хувьдаа бодож байна. Жижиг зүйл биш юм.

“Төдий бид мөн олз хайж Хятадын ихээхэн пүүсүүдээр оров. Эд юм элдэв зүйл нь ундуй сундуй пиг дүүрэн бөгөөд авъя гэвэл цөм л хэрэгтэй юм бөгөөд чухам хэрэгтэй юмыг эрвэл хэзээний хүн хүн зөөгөөд гүйцсэн ажээ. Харин нэгэн пүүсэнд Син Хэ Цзи Тян гэх хэдэн дэвтэр сонирхолтой ном байв. Түүнийг авав. Бас нэгэн шургуулгыг татаад үзвэл хүлгэн гэдэг нэгэн гар буу хэдэн сумтай байв. Түүнийг авав” хэмээн тэмдэглэлд гарч байна. Лам цагдаа Дамба тэр хоёр мөн л шоргоолж адил үймсэн бусдын бужигнаанд татагдан оролцож эзгүй пүүсүүдээр олз хайж байна. Хэрэгтэй зүйлсийг хүмүүс зөөгөөд дуусгасан байжээ. “Харин нэгэн пүүсэнд Син Хэ Цзи Тян гэх хэдэн дэвтэр сонирхолтой ном байв. Түүнийг авав” хэмээн гарч байна. Эндээс ном эрдэмд дуртай залуу хархүүгийн хүсэл эрмэлзэл мэдрэгдэх агаад бусад хүмүүс шиг гурил будаа, даав даалимба зэрэг бараа товарт шунасангүй. Харин ховор ном олж авсан аж. Тэр Тогтох тайжийнд үрчлүүлээд байхдаа тэдний хүү Эрхэмбаярын хамт тухайн цаг үеийн өндөр боловсролтой эрдэмтэн мэргэдээр ном заалгаж манж, хятад хэлний мэдлэгтэй болж гэрийн чамгүй сайн боловсрол эзэмшсэн гэдэг билээ. Хятад хэлний мэдлэг нь ном шилж сонгож авч буйгаас шууд мэдрэгдэж байна. Мөн да лам Хасбаатараас гуйгаад олж авч чадаагүй гар буюугаа хэдэн сумны хамт олж авчээ. С.Буяннэмэх цаашдын хувьсгалт тэмцэлд идэвхийлэн оролцох чин хүсэл эрмэлзэлтэй байгаа нь Хасбаатар ламтнаас буу гуйж, хаягдмал пүүсийн байрнаас гар буу олж авч байгаа энэ баримтаас харагдана. Өөрийгөө бэлтгэж байна. “Гэнэт үзвэл манай нөгөө

нөхөр маань харин өөр тийш явжээ. Яаран мэгдэн гарч ирэв. Олсонгүй, аргагүй болоод цааш ганцаар явав. Гудамжаар орос монгол цэрэг ба энгийн тэрэг чаргатай хүмүүс ямагт давхилдах нь үзэгдэнэ. Цааш би бас нэгэн хашаанд оров. Нэг ч улаан хөлтэй амьтангүй бөгөөд хүв хүйтэн, зэв зэвэргэн хөндий байшингууд онгойлцоно. Хашааны гадуур эргэн тойрон гал түймэр, бархираан шархираан болж л байна. Би нэлээн бүдүүн зүрх гаргаж баруун тийш хандсан нэг их байшинд орж үзэв. Үүдийг онгойлгон ороод ажиглан зогсож байтал гэнэт шалан дахь зоорины нүхнээс нэгэн ув улаан гар миний өөдөөс сарвасхийж цухуйгаад дахин үзэгдэхгүй болов. Миний айсныг хэлэх үү, зүрх түг түг хийж сандрахдаа харин хөдөлж чадахгүй болоод тэндээ нэлээд зогсож, хэзээ хойно сая айсан хүн мэт гүйн гарч гудамжнаа хүртэл хоёр монгол цэрэг нэгэн орос цэрэг явж байна. Ай нөхөд нөхдөө нааш ир гэж галзуурсан хүн мэт дуудав. Тэр гурав хүрч ирээд яв юу болов гэж байна. Ай нөхөд энэ байшин дотор газар дор нэг буг байна. Би айж үхэхийг шахав. Та нар очиж үзэхгүй юү гэв. Мөнөө гурав мориноос бууж, буу зэвсгээ барилцан их л сүртэй орж очив. Би ч зүрх орж тэдний хойноос дагаж оров” хэмээн тэмдэглэл үргэлжилж байна.

**И**х үймээн самуун дунд төөрөлдөж С.Буяннэмэх хамт явсан нөхрөөс зам салжээ. Эрж хайгаад лам цагдаа Дамбыг олсонгүй. Гудамжаар орос монгол цэрэг, тэрэг чаргатай энгийн иргэд бүгдээрээ л яаран давхилдах нь үзэгдэнэ гэжээ. Залуу хүний саваагүй сониуч занд хөтлөгдөж С.Буяннэмэх нэгэн хашаан дахь хүн амьтангүй хүв хүйтэн, зэв зэвэргэн байшингуудын нэгэнд хөл

тавин орж үзнэ. Эргэн тойронд гал түймэр оволзож, гудамжаар дүүрэн бархираан шархираан болж байсан гэжээ.

Байшингийн дотоод байдлыг ажиглан зогстол шалны “зоорины нүхнээс нэгэн ув улаан гар миний өөдөөс сарвасхийж цухуйгаад дахин үзэгдэхгүй болов. Миний айсныг хэлэх үү, зүрх түг түг хийж сандрахдаа харин хөдөлж чадахгүй болоод тэндээ нэлээд зогсож, хэзээ хойно сая айсан хүн мэт гудамжнаа гүйн гартал хоёр монгол цэрэг нэгэн орос цэрэг явж байна. Ай нөхөд нөхдөө нааш ир гэж галзуурсан хүн мэт дуудав” хэмээн бичсэн байна. Үйл явдал улам хурцдан өрнөж эл товчхон тэмдэглэл адал явдалт зохиол адил уншигдаж байна. Дүр дүрслэл, хэл хэллэг нь нэн тод, туйлын ойлгомжтой аж. Айж цочирдсон С.Буяннэмэхийн зүрх нь түг түг дэлсэж, хөшөө адил хөдөлж чадахгүй болж байна. Хэзээ хойно сая ухаан ороод гадагш гудамжинд гүйн гарч монгол, орос гурван цэргийн туслалцааг авч байна. Тэднийг галзуурсан хүн мэт дуудав гэж хүч оруулжээ. Тэр гурав хүрч ирээд яав юу болов гэхэд нь “энэ байшин газар дор нэг буг байна. Би айж үхэхийг шахав. Та нар очиж үзсүгэй гэв” гэж үнэнээ хэлж байх аж. “Мөнөөх гурав мориноос бууж, буу зэвсгээ барилцан их л сүртэй орж очив. Би ч зүрх орж тэдний хойноос дагаж оров” гэжээ. Зугаатай болоод үнэмшилтэйгээр дүрслэгджээ.

**Ж**ижиг гэхгүй анзаарах ёстой нэг зүйл энд байна. Хил хязгаар Хаиагад энэ үед орос цэрэг нэгэнт орж ирээд монгол цэргүүдтэй хамт 1921 оны ардын хувьсгалын үйл хэрэг, зэвсэгт тэмцэлд идэвхтэй оролцож эхэлснийг харуулна. Монгол Улсын шинэхэн түүхэнд энэ тухай дэлгэрэнгүй

бичиж тэмдэглэсэн зүйл төдийлөн тааралддаггүй билээ. “Тэд нар ормогц мөнөөх зоорины нүхэн дээр хүрээд зөндөө дуудав. Гарч ир, гарч ир гэнэ. Үнэндээ юу ч гарч ирсэнгүй. Мөнөөх цэргүүд зэргээр нүх рүү буудав, буудав. Ер чимээ ч үгүй. Мөнөөх орос цэрэг ташаандаа зүүсэн ширмэн бөмбөгийг суга татан аваад та нар хойшоо бай гэв. Бид нар гурав дөрвөн алхам ухрав. Гэнэт нүхэн дотор пис гэж галт бөмбөг тэсрэв. Арай үхээгүй бололтой дуу ёо ёо гэж нүхэн дотор сонстоно. Тэр тэсэрсэн бөмбөгний өмхий гэдэг нь үнэртэхийн аргагүй. Сонсвол орос цэрэг хэлрүүн: Үүний дотор орох хэрэгтэй. Та нарын хэн орно, ор гэж байна. Тийм аймшигтай нүхэнд орох зүрхтэй хүн хэн байх билээ гэж санаж байв. Ер орох хүн олдохгүй хойш сууна. Мөнөөх улаан цэрэг их л уурлан хараал тавиад нэг мэдсэн харин өөрөө орж явна, яасан зүрхтэй золиг вэ гэж нөгөө хоёр нь инээж байна” хэмээн “Өчүүхэн тэмдэглэл” цааш үргэлжилжээ. Үйл явдал нь дүрслэлт өгүүллэг адил өрнөжээ. Орос, монгол цэргүүд эхлээд нүхэн зооринд нуугдагчийг бушуухан гарч ир гэж дуудаад үгэнд нь орохгүй болохоор зэрэг зэрэг буудаж байна. Бас л гарч ирсэнгүй. Тэгмэгц орос цэрэг ташаан дахь ширмэн бөмбөгийг суга татан мулталж аваад зоорь руу хаяж дэлбэлж орхино. Ёо ёо гэх дуун нүхэн дотроос сонстоно. “Тэр тэсэрсэн бөмбөгний өмхий гэдэг нь үнэртэхийн аргагүй” гэж С.Буяннэмэх онцгойлон тодотгосон аж. Орос цэрэг хамт яваа монгол цэргүүдийг зоорь руу орох хэрэгтэй, хэн орох вэ гэж асуухад зүрхлэх хүн олдсонгүй. Улаан цэрэг их л уурсан хараал урсгаад өөрөө явж орно. Үлдсэн хоёр монгол цэрэг түүнийг яасан зүрхтэй золиг вэ хэмээн инээлдэнэ гэжээ.

С.Буяннэмэх хүүхэд байхдаа Хүрээн дэх орос сургуульд орж орос хэл бичигт суралцсан тул тэр орос цэргийн хэлэх үг, тавих хараал зэргийг цөмийг ойлгож байгаа нь эндээс харагдана. Мөн орос, монгол цэргүүдээс уг үйл явдал, үзэгдэл юмсад хандах хандлагыг маш тодорхойгоор илэрхийлэн гаргасан нь туйлын сонирхолтой. С.Буяннэмэх болоод тэр хоёр монгол цэрэг буг чөтгөр гэсэн сүсэг бишрэлд илүүтэй автагдаж нүхэн зоорь руу орохоос хойш сууж ухарч байхад орос нөхөрт тийм зүйл байсангүй тул хараал урсгаад өөрөө орж байх жишээтэй аж. “Удалгүй мөнөөх орос цэрэг нэгэн улаан нялга болсон хятадыг чирсээр гарч ирэв. Нүүр нь цөм цус болсон бөгөөд шанаан дээр нь бага шархадсан боловч өөр гэмтсэн газаргүй нь гайхалтай байв. Тэр нь үнэндээ гамин ч бус нэг муу ажилчин хятад бололтой байв. Манай хэдэн цэрэг барьж хүлээд тууж одов. Хэрэггүй ч юм болов уу гэж энэрэх сэтгэл төрж байв. За больё дахиж ийм юмтай дайралдвал золиг орхино гээд мориндоо мордож Алтанбулагийн тийш одов. Олон монгол цэрэг, ард янз бүрийн хүмүүс Дамбадугар хэмээх буриадын хашаанд бужигнаж байгаа бөгөөд энд тэнд шатсан шатаагүй, хэмхэрхий бүтэн эд бараа авдар сав овоолсон нь зөндөө бөгөөд заримаас нь хиншүү гарна” хэмээн тэмдэглэл үргэлжилжээ.

С.Буяннэмэхийг үхтэл айлгасан улаан нялга болсон хятад нь гамин биш харин гэм зэмгүй хөлсний ажилчин байсныг үзэж мэдэрсэн тэр бээр ихэд өрөвдөж энэрэх сэтгэл төрж өөрийн үйлдэлд гэмшиж байна. Дахин ийм юм тохиолдвол анзааралгүй орхиж байя гэж бодоод мориндоо мордож Алтанбулагийн тийш одов гэжээ. Эргэн тойронд өнөөх л цэрэг, ард зэрэг янз бүрийн олон хүн бужигналдана. Энд тэндгүй

эвдэрсэн, шатсан байшин барилга, эд бараа, авдар сав ундуй сундуй хөглөрч, утаа хэншүү үнэртэнэ гэжээ. Хэдийгээр дээрх зураглал 1920 оны үйл явдлынх боловч 1921 оны 3 дугаар сарын 18-ны монгол цэргийн дайралт, ялалтын дараах Хиагтын байдал ч ер нь нэг иймэрхүү дүр төрхтэй байсан байж таарна гэж эрхгүй бодогдож байгаа юм.

“Миний бие ийш тийш харж явтал харин нэгэн таних хүн тааралдав. Өөр хүн ч бус, урьд намайг намд элсүүлэх гэж байсан утасны хорооны нөхөр Дамбадорж байв. За нөхөр чи ирсэн нь маш сайн. Тэр урдах хөх цонхтой байшинд орж Бодоотой уулз гээд түүний бие ихэд яарч яваад өгөв” гэсэн байна. Бүгд л ямар нэгэн юманд яарсан сандарсан улс тэмдэглэлд дүрслэгджээ. Тэр дотор өөрийг нь намд элсүүлэх гэж байсан утасны хорооны Дамбадоржтой С.Буяннэмэх тааралдахад “За нөхөр чи ирсэн нь маш сайн. Тэр урдах хөх цонхтой байшинд орж Бодоотой уулз” гэж байна. С.Буяннэмэхийг Алтанбулагт хүлээсэн хүн нэг биш байсан, тэдэн дотор нь МАН-ын анхны том зүтгэлтний нэг Дамбадорж бас байжээ. Тэр түүнийг намд элсүүлэх гэж бэлтгэлийг хангаж байж. “Алтанбулаг ба дээд шивээ хотын газар ардын намын нөхөд сая хуралдаж цэргийг элсэн байгуулж уул их хэргээ үүсгэн явуулах тэр цагт “Ардын намын арван зүйлийн зорилт ба ард түмэнд тунхаглан зарлах бичиг” тэргүүтнийг олж үзээд учир явдал ба санаа зорилтыг бүрнээ мэдэж сайшаах сэтгэл үнэнээс хөдөлж энэхүү намд энэ их хэрэг үйлсэд зүтгэлцэж үхэвч гомдолгүй үнэн байдал учраа илтгэж ардын намын жинхэнэ гишүүн” болсон гэж С.Буяннэмэх бичиж үлдээсэн байдаг юм (Баасансүрэн.Т, 2019).

“Өчүүхэн тэмдэглэл” бол Алтанбулаг ба Дээд ивээ хотын газар ардын намын нөхөд тал талаас цугларч цэрэг эрсийг элсүүлэн 1921 оны ардын хувьсгалыг бүрэн ялалтад хүргэхээр бэлтгэж байсан яг тэр цаг үеийн үйл явдлын талаарх нийтлэл юм.

**Д**амбадоржийн зааж өгсөн хөх цонхтой байшинд очиж Бодоотой дуулзаж танилцсан тухайгаа С.Буяннэмэх доорх байдлаар дүрслэн бичсэн аж. “Түүний заасан хөх цонхтой байшинд орвол нэгэн шар лам модон тамга сийлж байна. Би нэлээд дуугүй зогсоод Бодоо гэгч хүн энд байна уу гэв. Тэр хүн нэлээд эелдэг зантай бөгөөд, байна, байна, би байна, чиний нэр хэн бэ, хаанаас ирэв гэж байна. Би нэрээ хэлээд Дамбадорж тан дээр оч гэсэн тул ирэв гэв. Тэр лам инээмсэглэж тийм, тийм чамайг бид сонссон маш сайн. “Одоо та энд бичгийн ажил хийх хэрэгтэй” гэв. Энэ ямар газар вэ гэвэл Гадаад хэлтэс гэж байна. Түүний сийлж буй тамгын үсэг нь түр засгийн газар, гадаад дотоод хэлтэс хэмээх үсгүүдтэй бөгөөд тэр нь үнэндээ сийлбэрч лам бус ардын түр засгийн газрын гадаад хэлтсийн дарга байжээ. Даруй би тэнд суув. Талх мах идэх юм зөндөө байна. Би ч идэж ууж суув. Янз бүрийн хүмүүс орж гарч ер тасралтгүй байна. Нар ч орой болов. Нэгэн тасалгааг нь би ганцаар эзлэв. Тэр Бодоо гэгч нэгэн бичиг авч надад өгөөд үүнийг хуулж бай гэв. Миний анх тэргүүний албан ажилд орсон нь тэр байв”

Ардын засгийн газрын анхны Ерөнхий сайд Догсомын Бодоо бол Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нарын хамтран зүтгэгч, ардын намын нууц бүлгэмийн анхны гишүүдийн нэг агаад 1913 оны 3-р сарын 6-нд анхны дугаар нь нийслэл Хүрээнд хэвлэгдэн гарсан Монголын анхны “Шинэ толь хэмээх

бичиг” сонины сурвалжлагчаар ажиллаж байсан туршлагатай бичээч байв. Тийм учраас С.Буяннэмэхэд илүү дотночлон хандаж “тийм тийм, чамайг бид сонссон, маш сайн” гэж тааламжтайгаар хүлээн аваад “Одоо та энд бичгийн ажил хийх хэрэгтэй” гээд нэгэн бичиг авч өгөөд үүнийг хуулж бай гэж хэлж байна. Бичиг үсгийг гэрийн боловсролоор эзэмшсэн С.Буяннэмэх Ардын нам, засагт ихэд хэрэгцээтэй хүн болох нь эндээс харагдаж байна.

Д.Бодоог эелдэг зантай гэсэн байх бөгөөд түүнийг ороход модон тамга сийлж суусан гэж бичжээ. Бодоогийн тамга сийлж суусан тэр газар нь Гадаад хэлтэс байсан байна. Түүний сийлж буй тамгын үсэг нь түр засгийн газар, гадаад дотоод хэлтэс хэмээх үсгүүдтэй байв гэж С.Буяннэмэх бичиж үлдээсэн аж. Д.Бодоог Монгол Ардын Намын модон тамгыг сийлсэн гэж бичиг баримтад тэмдэглэсэн байдаг бөгөөд С.Буяннэмэхийн бичсэнээс үзэхэд тэр бээр бас Түр засгийн газрын гадаад, дотоод хэлтсийн модон тамгыг мөн нэгэн адил урласан сийлбэрч, тухайн цаг үед Түр засгийн газрын гадаад, дотоод хэлтсийн даргаар ажиллаж байсан нь уг бичвэрээс ойлгогдож байна. Энэ бол Монгол Ардын нам ба Ардын түр засгийн газрын түүхэнд тэмдэглэгдэж үлдэх учиртай маш чухал баримт мөн болно.

Тэнд идэх уух юм элбэг дэлбэг байсан агаад янз бүрийн хүн тасралтгүй орж гарч байсан гэж С.Буяннэмэх бичжээ. Түүнд нэгэн тасалгааг гаргаж өгсөн байна. Ингэж залуу хүү С.Буяннэмэх Ардын засгийн газрын анхны ажилтны нэг болсон байна.

Цааш залгуулан уншвал “Нэлээд орой болов. Нэг нь нарийвтар өндөр бөгөөд нөгөө нь арай түүнээс богино орос монгол хоёр хольцолдсон хувцас-

тай бүрэн зэвсэгтэй, бодвол цэргийн дарга бололтой ийм хоёр хүн орж ирэв. Тэр хоёр орж ирээд манай гадаад хэлтсийн даргатай зэрэгцэн суув. Энэ лав нэлээд их хүмүүс буй заа гэж би санаж байв. Гэнэт сонсвол тэр өндөр хүн нь “энэ ямар хүн хэн бэ” гэж намайг асууж байна. Түүний хамт орж ирсэн нөгөө нөхөр нь инээмсэглээд энэ чинь мөнөөх шүлгийг бичсэн хүн шүү дээ гэж харин намайг таньж байна. Тэр хүн түүнийг сонсоод даруй инээмсэглэх царайгаар намайг нэлээд ажиглав. Урьд хэдэн өдрийн өмнө “таван мөнгө хүрэхгүйгээр түмэн ардыг худалдсан халхын ноёд” гэх шүлэг бичээд Дамбадоржид өгсөн бөлгөө. Түүнээс өөр шүлгийг урьд хожид ер бичээгүй явсан тул лав түүнийг эдгээр нөхөд үзээд тийнхүү ярилцаж байгаа буй заа гэж дотроо тааварлаж байв. Удалгүй тэр хоёр хүн Бодоотой нэлээд олон юм яриад гарч одов” гэжээ.

Тэдний өрөөнд өндөр нам хоёр хүн орж ирж Бодоотой уулзаж байна. Орос монгол хоёр хольцолдсон хувцастай, бодвол цэргийн дарга бололтой бүрэн зэвсэглэсэн гэж зохиогч тодотгосон байна. “Энэ лав нэлээд их хүмүүс буй заа гэж би санаж байв” гэжээ. Өндөр хүн нь Бодоогоос “энэ ямар хүн хэн бэ” гэж асуухад гаднаас хамт орж ирсэн намхан нөхөр нь инээмсэглээд “энэ чинь мөнөөх шүлгийг бичсэн хүн шүү дээ” хэмээн түүнийг танимхайрч байна. Урьд хэдэн өдрийн өмнө “таван мөнгө хүрэхгүйгээр түмэн ардыг худалдсан халхын ноёд” гэх шүлэг бичээд Дамбадоржид өгсөн бөлгөө. Түүнээс өөр шүлгийг урьд хожид ер бичээгүй явсан тул лав түүнийг эдгээр нөхөд үзээд тийнхүү ярилцаж байгаа буй заа гэж дотроо тааварлаж байв” гэж С.Буяннэмэх “Өчүүхэн тэмдэглэл”-дээ өгүүлжээ.

С.Буяннэмэх уг шүлгийг 1920 онд бичжээ. “Таван мөнгө хүрэхгүйгээр түмэн ардыг худалдсан халхын ноёд” шүлэгт тусгаар тогтнолоо найр тавьж өгсөн 1915 оны гэрээ, харийн булаан эзлэгчид халдан түрэмгийлсэн 1919-1920 оны үйл явдлыг үзүүлсэн бөгөөд харамсалтай нь хадгалагдаж үлдсэнгүй. Уг шүлгийн утга агуулгыг Дамбадорж, Бодоо нар болоод тэнд орж ирсэн өндөр, нам хоёр хүн их сайн мэдэж талархан сайшааж байсан нь дээрх өгүүлэмжээс тод харагдаж байна. Харин цэргийн дарга бололтой бүрэн зэвсэглэсэн тэр хоёр хүнийг С.Буяннэмэх хэн болохыг мэдэхгүй байв.

“Хэзээ хойно унтах үед Бодоо гуай оройны орж ирдэг хоёр хүнийг хэн гэдэг бол гэж асуув. Бодоо инээн хэлрүүн: “Тэр миний баруун талд суусан хүн бол манай ардын цэргийн тэргүүн жанжин Сүхбаатар гэгч бөгөөд нөгөө нь дэд жанжин Чойбалсан гэгч болой гэв. Нэр алдрыг нь сонссон боловч зүс царайг нь сая үзэв гэж баясаж байв. Тэндээс хойш цөмийг таних мэдэх ба ярилцах хөөрөлдөх сайн нөхөр боллцон ер айх сэжиглэх явдалгүй болов” хэмээн “Өчүүхэн тэмдэглэл”-ийн дараагийн өгүүлбэрүүд үргэлжилж байна.

**И**нгэж залуу тэмцэгч С.Буяннэмэх их жанжин Сүхбаатар, түүний орлогч Чойбалсан нартай нүүр учран танилцжээ. “Нэр алдрыг нь сонссон боловч зүс царайг нь сая үзэв гэж баясаж байв. Тэндээс хойш цөмийг таних мэдэх ба ярилцах хөөрөлдөх сайн нөхөр боллцон ер айх сэжиглэх явдалгүй болов” хэмээн С.Буяннэмэх бичиж үлдээсэн байна. Өөрөөр хэлбэл МАН ба Ардын түр засгийн газрын бүрэн итгэлт журмын нэг нөхөр нь болж итгэмжлэгдсэн байна.

Энэ нь Оросын хувьсгалч Б.Шумяцкийн бичсэнээр 1920 оны 4-р



сар бололтой. Тэр бээр “Буяннэмэх ингэж цаг үеэ ухамсарлаж, амьдралын зорилгоо таньж 1920 оны 4-р сард... Сүхбаатарын байгуулсан хувьсгалт бүлгэмд элссэн” (Шумяцкий.Б, 1966) гэжээ.

Эдгээр баримт сэлтийг иш үндэс болгож доктор С.Лувсанвандан нь С.Буяннэмэхийг 1921 оны ардын хувьсгалын байлдагч, МАН-ын ууган гишүүн бөгөөд ардын төрийн анхны зүтгэлтний нэг болжээ гэж дүгнэсэн байдаг (Лувсанвандан.С, 1987).

“Хэдэн өдөр өнгөрсний хойно Бодоо гаднаас орж ирээд надад хэлрүүн: За хүүе чамайг төв хорооны хурлаар хэлэлцэж Эрхүү хотод суух төлөөлөгчөөр томилсон тул одоо даруйхан явах хэрэгтэй. Замын зардал хэрэгслийг чинь сангийн хэлтэстэй ярилцсан тул тэндээс очиж авсугай гэв. Тэр Эрхүү хот бол Байгаль далайн хойно байдаг бөгөөд тэрхүү хотод алс дорнод зүгийн коминтерны салбар болох газар байна. Тэнд манай итгэмжтэй нөхөр Ринченов гэгч бий бөгөөд тэндээс уламжилж манай Монголд туслах цэрэг зэвсгүүд ирнэ. Бас тэндээс манай сонин ба хэвлэлүүдийг хэвлэж гаргана. Чиний бие очмогц чамд тэрхүү нөхөр Ринченов цөмийг зааж хэлж өгнө гэж ер учир нь олдохгүй янз бүрийн орос монгол үг хольж хутгаж нэлээд хэлж өгөв. Нарийн учрыг сайн ч мэдсэнгүй юу ч атугай явах л хэрэгтэй болов” гэж С.Буяннэмэх “Өчүүхэн тэмдэглэл”-ээ цааш үргэлжлүүлжээ.

МАН-ын Төв Хорооны шийдвэр гарч, түүнийг Эрхүү хотод суух төлөөлөгчөөр томилсон байна. Хоёр чухал ажлыг гүйцэтгэх үүрэг хүлээжээ. Ринченов гэгчтэй уулзаж Монгол Улсад туслах цэрэг зэвсэг авах, улмаар Ардын нам, засгийн газрын сонин хэвлэлүүдийг хэвлэж гаргах нэн хариуцлагатай

ажилд ийнхүү тохоон томилогдож байна. Нарийн учрыг сайн ч мэдсэнгүй юу ч атугай явах л хэрэгтэй болов” гэж С.Буяннэмэх тэмдэглэж үлдээжээ. Энэ бол МАН, Ардын засгийн газрын төв хэвлэл “Монголын үнэн” сониныг Эрхүү хотноо хэвлүүлж Монголд нууцаар оруулж ирж тараах их үйлсийн эхлэл тавигдаж байгаа нь энэ юм. Амин чухал баримтын нэг мөн. “Монголын үнэн” сонины анхны дугаар 1920 оны 11 дүгээр сарын 10-нд гарсан байдаг. Нийтдээ 6 дугаар хэвлэгдсэн бөгөөд гардан эрхэлж гаргагч нь С.Буяннэмэх байв.

Одоо “Өчүүхэн тэмдэглэл”-ийн төгсгөл хэсгийг уншигч танд толилуулан сонирхуулъя. Зохиогч: “Төдий сангийн хэлтэст очиж замын хэрэгсэл гэж хоёр толгой чисчүү, хоёр толгой даавуу, нэг бага хүүдий цагаан будаа ийм юм хүлээж аваад нэлээд их юмтай болов гэж баярлаж явав. Бас тэр гадаа овоолгоотой юмнаас хэрэгтэй юмаа авагтун гэж сангийн хэлтэс хэлэв. Очиж үзвэл төдий л хэрэгтэй юмгүй, харин нэг орос шар товчтой дээл байна. Энэ нь харин орос газар явахад хэрэгтэй юм гэж авав. Бас нэг шинэвтэр хөнжил дэвсгэр байна. Түүнийг авав. Миний явах хэрэгсэл ч бараг гүйцэв. Тэндээс би гадаад хэлтэст очиж бичиг тэмдэг шийтгүүлж аваад явахыг завдан байтал саяхан тэр өдөр миний нагац эцэг болох Лувсан гэгч хүн намайг эрж сураглаж хүрч ирсэн байжээ. Түүний биеийг гамингууд барьж хол баруун харуулуудад хэлмэрчлүүлэн явсан бөгөөд лав үхсэн буй заа гэж санасан бөлгөө. Гэтэл харин амьд хүрч ирснийг үзээд тэсгэлгүй баярлаж ядрал зүдрэлээ бага зэрэг ярилцаад түүний биеийг нөхдөд захиж бас чисчүүгээ түүнд өгөөд харилцан баясалцан дахин салахад хүрэв. Хүү

минь чи одоо хаа очих гэж байна гэж асуув. Ай би одоо албан хэргээр хойт орос улсад явна. Лав тийм удахгүй ирэх тул санаагаа зовоох хэрэггүй гэж би хэлэв. Өвгөн их л зовууртай хоцорсон боловч харин нөхөд түүнийг их л дотнолон үзэж засгийн газрын зарлага болгожээ” хэмээсэн байна.

Шинэ ажлын томилолт аваад Сангийн хэлтэст С.Буяннэмэх очиж хоёр толгой чисчүү, хоёр толгой даавуу, нэг бага хүүдий цагаан будаа-ийм юм хүлээж аваад нэлээд их юмтай болов гэж ихэд баярлаж байна. Гадаа овоолгоотой юмнаас орос шар товчтой дээл нэг ширхгийг, бас нэг шинэвтэр хөнжил дэвсгэр авч байна. Энэ үед гамингуудад баригдан хэлмэрчээр явсан, лавтай үхсэн буй заа хэмээн бодож байсан нагац эцэг болох Лувсантайгаа уулзан баяр дээр баяр нэмж ядрал зүдрэл мартагдаж байна. Чисчүү дээлээ түүнд өгч Холбоот Орос Улсад явах ажилтай болов. Удахгүй буцаж ирэх тул санаа зовох хэрэггүй хэмээн учирласан ч өвгөн их л зовууртай хоцорчээ. Түүнийг журмын нөхдөдөө захиж үлдээгээд явжээ. Нөхөд нь Лувсанг дотночлон үзэж засгийн газрын зарлага болгожээ гэсэн байна.

Үүн дээр “Өчүүхэн тэмдэглэлийн”-ийн сүүлчийн нэг өгүүлбэрийг нэмэн сонирхуулаад судалгааны бяцхан өгүүллээ дуусгая. Тэрхүү өгүүлбэрт: “Мисиевский гэдэг галт тэрэгний зог-

соолд анх би ирээд барааны улаан тэргүүдийг үзэж галт тэрэг гэгч ийм гайхалтай сонин байдаг ажээ гэж их л сонирхсон бөгөөд гагцхүү энэ байшинтай тэргэндээ даанч цонх хийхгүй яасан ухаан муутай хүмүүс вэ гэж гэмшиж улаан вагонд суугаад хойш явсан бөлгөө” хэмээжээ.

Алсыг зорин одооор анх удаа бух тэргэнд сууж үзэж буй нь энэ. Барааны улаан тэргүүд гэжээ. Ачааны галт тэргэнд суусан байна. Соёлыг гайхаж сонирхох сонжих нь дээд цэгтээ тулжээ. Гагцхүү энэ байшинтай тэргэндээ цонх хийчихдэггүй яасан ухаан муутай улс вэ хэмээн гайхан бодсоор ачаа тээврийн улаан вагонд суугаад Оросыг зорин оджээ. Дүгнэлт:

1. С.Буяннэмэхийн бичсэн “Өчүүхэн тэмдэглэл”-д нийтдээ амин чухал ач холбогдолтой гэж хэлж болохуйц 22 ширхэг баримт мэдээлэл байна. Эдгээрийг дотор нь ардын хувьсгал, түүний үндсэн гол зорилго, бэлтгэл ажил, зохион байгуулалттай холбоотой баримтууд ба Сономбалжирын Буяннэмэхийн өөрийнх нь амьдрал, уран бүтээлтэй холбоотой мэдээллүүд гэж хоёр ангилж болохоор байгаа юм.

2. 1921 оны ардын хувьсгалын үйл хэрэгт их бага ямар нэг байдлаар гар бие оролцсон Да лам Хасбаатар, Дамбадорж болон уг хувьсгалын удирдагч Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Д.Бодоо нартай холбоотой чухал мэдээллүүд, Орос улс, Эрхүү хотноо байрлах

«

**С.Буяннэмэхийн бичсэн “Өчүүхэн тэмдэглэл”-д нийтдээ амин чухал ач холбогдолтой гэж хэлж болохуйц 22 ширхэг баримт мэдээлэл байна.**

**Эдгээрийг дотор нь ардын хувьсгал, түүний үндсэн гол зорилго, бэлтгэл ажил, зохион байгуулалттай холбоотой баримтууд ба Сономбалжирын Буяннэмэхийн өөрийнх нь амьдрал, уран бүтээлтэй холбоотой мэдээллүүд гэж хоёр ангилж болохоор байгаа юм**

»

Алс дорнод зүгийн коминтерны салбартай тухайн цаг үед манай хувьсгалчдаас тогтоосон холбоо хэлхээ, хамтын ажиллагааны эхлэл хийгээд 1921 оны 3-р сарын 17-18-нд ардын журамт цэрэг Хиагт дахь гамин цэргийг Эх орноосоо хөөн зайлуулсан Түр засгийн газрыг Алтанбулагт байгуулсан зэргийг тодотгон судлахад уг үйл хэрэгт биеэр оролцож, нүдээр үзсэнээ тэмдэглэн буулгасан С.Буяннэмэхийн эл “Өчүүхэн тэмдэглэл” юугаар ч орлуулшгүй үнэт чухал тулгуур баримт мэдээлэл болох бүрэн үндэслэлтэй байна.

3. С.Буяннэмэхийн “Өчүүхэн тэмдэглэл” нь 1921 оны ардын хувьсгалын үйл хэргийн талаарх товч бөгөөд тод толь болж үлдэхүйц үнэхээрийн сайхан үнэт чухал нийтлэл болжээ. Өөр ийм нийтлэл монголын сэтгүүл зүйн түүхэнд үгүй юм. 1920-1921 оны ардын хувьсгалын түүхэн үйл явдал, тэмцэл ялалт, шинэ нийгмийн бүтээн байгуулалтыг өөрийн дуу шүлэг, зохиол бүтээлээрээ тал бүрээс нь тод томруунаар нээн үзүүлж чадсан Сономбалжирын Буяннэмэх бол 1921 оны ардын хувьсгалын гал цогтой гайхамшигт дууч нь яах ч аргагүй мөн билээ.

#### **Эшлэл**

1. Лэгсрэн овогт Тугалхүүгийн Баасансүрэн. Сономбалжирын Буяннэмэхийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлогт хийсэн ажиглалт шинжилгээ. УБ. 2019. 312 дахь тал.
2. Б.Шумяцкий. “Монголын Октябрийн 10 жилийн ой” /1931/. Эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл. МАХН-ын түүхийн институт. УБ. 1966.
3. С.Лувсанвандан. Монголын уран зохиолын дэвшил, социалист реализм. УБ. 1987. 239 дэх тал.

#### **Ашигласан ном зохиол**

1. “Монголын уран зохиолын дээжис 108 боть”. Сономбалжирын Буяннэмэх,

ХХIII боть. “Өчүүхэн тэмдэглэл. УБ. 1996.

2. Б.Шумяцкий. Монголын октябрийн 10 жилийн ой. /1931/. Эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл. УБ. 1966.
3. С.Лувсанвандан. Монголын утга зохиолын дэвшил, социалист реализм. УБ. 1987

#### **Summary**

In his scientific article, “A lot of information and the historical significance of the “Little Note””, Dr. T.Baasansuren for the first time conducted a detailed analysis of the article by Sonombalzhir Buyannemekh, written in 1920, from the point of view of journalism. The researcher found that this note on the preparation and development of the People's Revolution of 1921 contains 22 important facts and information that can be divided into documents relating to the People's Revolution of 1921, its main goal, preparation and organization, and information about the life and creative activity of S.Buyannemekh.

The author emphasizes the presence of invaluable facts related to D.Sukhbaatar, Kh.Choibalsan, D.Bodoo and other revolutionaries who led and organized the People's Revolution of 1921, as well as to the creation of the Provisional People's Government in Altanbulag. The author also notes that from this document one can obtain important information about the recruitment of the People's Army in Kyakhta and the contacts of the revolutionaries headed by D.Sukhbaatar, with Russia and the Far Eastern branch of the Comintern in the city of Irkutsk at that time.

“A small note” by S.Buyannemekh is a very important and valuable document, as a mirror reflecting in a concise and clear form the revolutionary people's movement and the events of 1920-1921. The author concludes that a journalistic note written by S.Buyannemekh, a singer and trumpeter of the People's Revolution of 1921, no longer exists in Mongolian journalism. This determines the historical value and great artistic significance of the “Little Note” of the great educator S. Buyannemekh, the author concludes.